

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 09 дүгээр
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүнээс 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулсанаар хуурамч шатахууны үйлдвэрлэлийг хязгаарлаж иргэдийг чанартай шатахуун хэрэглэх боломжоор хангах, мөн татварын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хуулийн төслийн талаарх Засгийн газрын байр суурийг тодруулж, өргөн мэдүүлсэн төсөл нь Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр түдгэлзүүлсэн зохицуулалтаас өөрчлөгдсөн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Г.Ганбаатар нар хуурамч шатахууны нийлүүлэлттэй холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгжүүдэд учруулсан хохирлыг тооцсон судалгаа байгаа эсэх талаар болон газрын тосны дайвар бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулснаар Дорноговь аймагт баригдаж байгаа Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд газрын тосны дайвар бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах нь үндэсний бусад үйлдвэрийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Жаргалсайхан нар стандартын шаардлага хангаагүй шатахуунаар үйлчилж байгаа аж ахуйн нэгжүүдийг олон нийтэд зарлан, иргэдэд учруулсан хохиролд нь хариуцлага хүлээлгэх боломжтой эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан. Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Ж.Алдаржавхлан нар хуулийн төслийн тооцоо, судалгааг дахин нягтлах, хуурамч шатахууны үйлдвэрлэлд төрөөс тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй гэсэн саналыг хэлж, газрын тосны дайвар бүтээгдэхүүнийг түүхий эд болгон ашигладаг үйлдвэрүүдийн талаар болон хуулийн төсөл батлагдвал Үндсэн хуулийн цэцэд дахин маргаан үүсэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр хуурамч шатахуун болон импортоор орж ирж байгаа шатахууны чанарын ялгааны талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хуурамч шатахууны борлуулалтыг зах зээлээс гаргаж, үйлдвэрлэлд хяналт тавих, хариуцлагын тогтолцоог сайжруулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг газрын тосны үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулбал дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний өртөг өсөх магадлалтайг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан стандартад нийцээгүй шатахуун үйлдвэрлэж иргэдийн өмч, хөрөнгөд учруулсан хохиролд эрүүгийн

хариуцлага хүлээлгэх асуудлыг нарийвчлан зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь хуурамч шатахууны нийлүүлэлтээс болж орон нутгийн иргэд хохирч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын Тамгын газраар хууль зүйн зөвлөмжийг гаргуулах, мөн газрын тосны дайвар бүтээгдэхүүнийг хуурамч шатахуунаас гадна бусад үйлдвэрлэлийн салбарт ашигладаг тооцоо, судалгааг нарийвчлан тооцох нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйл 22.3.9 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас хууль зүйн зөвлөмж гаргуулах горимын санал гаргаж санал хураалгахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.


Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Х.ГАНХУЯГ